



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2023/192/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Баталгаат тооцоолол аудит ХХК

Захирал: М.Буянбулган

Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СХЗГ	Стандарчлал хэмжил зүйн газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Амьдагчдын өргөн нөмөр 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.04 № 115
тантай _____ ны № _____ Ү

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВИЙН ДАРГА Ц.БҮРЭНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт хэмжил зүйн хэлтэс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд аймгийн Засаг даргын нэрэмжит "Чанарыг эрхэмлэгч" шагнал олгох журмын төслийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2022 оны А/262 тоот захирамжаар батлуулж, хэрэглэгчдэд чанар, аюулгүй шаардлагыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж буй орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, Стандарт хэмжил зүйн газартай хамтран MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо-шаардлагатай стандарт"-ын чиглэлээр сургалтыг зохион байгуулсан.

Аудитын гол асуудал

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай"

07.02.2023/12:44:01

006020122

705 дугаар тогтоолын дагуу нийт 9,385.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан.

Ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэ шинэчлэн тогтоох хүсэлт явуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны "Үндсэн хөрөнгө дахин үнэлж, ашиглалтын хугацаа болон шинэчилсэн үнэ тогтоох зөвшөөрөл олгох тухай" 657 дугаар тогтоолын дагуу 52,626.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данс бүртгэлээс хааж, шинээр 27,948.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан.

2022 онд Стандарт хэмжил зүйн газрын болон аймгийн Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 98 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна. Аудитаар байгууллагын үйлчилгээнээс үндсэн орлогын төлөвлөгөөг бүрдүүлдэг, өөрийн тээврийн хэрэгсэлгүй ч тээвэр шатахуунд бараа, ажил үйлчилгээний зардлын 1.6 хувийг батлагдсаныг эрсдэлтэй асуудлын хүрээнд тодорхойлсон. 2022 онд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 36,520.0 мянган төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 58,659.0 мянган төгрөг буюу 160.6 хувиар биелүүлсэн. Аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Official stamp and signature of the State Auditor. The stamp is in Mongolian and contains the text "ТӨР" (State) and "АУДИТОР" (Auditor). The signature is in black ink.

Б.ЭРДЭНЭ

03-chinghee@2023AM001

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13 425 463.00</u>	<u>16 070 493.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
321	Үнэт цаас	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13 425 463.00	16 070 493.00
354	Хангамжийн материал	13 028 563.00	15 824 043.00
35410	Бичиг хэргийн материал	299 200.00	132 500.00
35420	Аж ахуйн материал	12 729 363.00	20 600.00
35470	Бусад хангамжийн материал	-	15 670 943.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>319 722 690.11</u>	<u>337 361 932.23</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	319 722 690.11	337 361 932.23
392	Биет хөрөнгө	309 388 333.40	327 143 370.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	236 311 280.00	236 311 280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27 483 345.72)	(36 644 460.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183 972 920.00	180 662 988.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97 898 114.71)	(69 023 231.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28 102 583.00	22 570 580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13 616 989.17)	(6 733 785.15)
393	Биет бус хөрөнгө	10 334 356.71	10 218 561.75
39301	Програм хангамж	503 180.00	503 180.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(194 923.29)	(310 718.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	10 026 100.00	10 026 100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>333 148 153.11</u>	<u>353 432 425.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	<u>2 250 000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	2 250 000.00
413	Өглөг	0.00	2 250 000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	300 000.00
4136	Бусад өглөг	0.00	1 950 000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1 950 000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>333 148 153.11</u>	<u>351 182 425.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	333 148 153.11	351 182 425.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130 294 986.00	130 294 986.00
51101	Өмч: - төрийн	130 294 986.00	130 294 986.00
512	Хуримтлагдсан үр дүн	(31 364 786.23)	(13 330 514.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(31 364 786.23)	(31 364 786.23)
51220	Тайлант үеийн үр дүн	-	18 034 272.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234 217 953.34	234 217 953.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>333 148 153.11</u>	<u>353 432 425.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	288,664,790.00	303,310,249.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,537,990.00	107,686,169.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,537,990.00	107,686,169.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,537,990.00	107,686,169.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,654,140.00	58,659,001.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	883,850.00	49,027,168.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,126,800.00	195,624,080.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	245,126,800.00	191,426,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	245,126,800.00	191,426,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	4,197,880.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	897,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	268,052,123.73	285,275,976.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	268,052,123.73	285,275,976.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,117,827.73	243,461,206.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,330,451.00	143,889,694.00
210101	Үндсэн цалин	113,628,719.00	107,848,149.00
210102	Нэмэгдэл	34,434,532.00	32,206,545.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,267,200.00	3,835,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,479,635.85	17,832,539.26
210201	Тэтгэврийн даатгал	14,530,223.02	12,157,575.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,285,213.22	1,430,255.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,013.39	1,144,204.68
210204	Ажилгүйдлийн даатгал	302,566.26	281,863.82
210205	Эрүүл мэндийн даатгал	3,025,619.96	2,818,639.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,475,044.00	17,624,797.00
210301	Гэрэл, цахилгаан	777,044.00	1,193,497.00
210302	Түлш, халаалт	15,210,480.00	15,210,480.00
210303	Цэвэр, бохир ус	487,520.00	1,220,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,169,733.70	9,288,070.00
210401	Бичиг хэрэг	1,661,780.00	797,350.00
210402	Тээвэр, шатахуун	3,380,000.00	4,617,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,147.00	2,537,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	468,450.00	246,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510,900.00	1,089,100.00
210408	Бараа материал акталсны зардал	2,180,456.70	0.00
2105	Нормативт зардал	741,930.00	2,866,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	741,930.00	541,200.00
210502	Хоол, хүнс	0.00	2,325,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,696,520.00	3,307,200.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,840,720.00	50,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	101,350.00	0.00
210604	Урсгал засвар	754,450.00	3,257,200.00
2107	Томилолт, зочны зардал	6,752,500.00	6,595,200.00
210702	Дотоод албан томилолт	6,752,500.00	6,595,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307,792.00	1,342,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,000.00	114,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	110,000.00
210807	Газрын төлбөр	15,392.00	15,390.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	17,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	58,400.00	1,013,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,164,221.18	40,715,365.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,876,060.00	2,693,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,326,350.00	2,491,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,961,811.18	35,531,045.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,934,296.00	41,814,770.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,880,000.00	19,309,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	16,749,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,880,000.00	2,560,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	22,505,770.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	22,505,770.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,054,296.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,054,296.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>20,612,666.27</u>	<u>18,034,272.12</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,165,850.00)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>19,446,816.27</u>	<u>18,034,272.12</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>287,780,940.00</u>	<u>254,283,081.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>37,654,140.00</u>	<u>58,659,001.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	37,654,140.00	58,659,001.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,654,140.00	58,659,001.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,654,140.00	58,659,001.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>250,126,800.00</u>	<u>195,624,080.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	245,126,800.00	191,426,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	245,126,800.00	191,426,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	4,197,880.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	897,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>239,370,460.00</u>	<u>249,923,381.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>239,370,460.00</u>	<u>249,923,381.00</u>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230,436,164.00	208,108,610.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,330,451.00	143,889,694.00
210101	Үндсэн цалин	113,628,719.00	107,848,149.00
210102	Нэмэгдэл	34,434,532.00	32,206,545.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,267,200.00	3,835,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,207,340.00	17,832,539.26
210201	Тэтгэврийн даатгал	14,543,540.00	12,157,575.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,415,900.00	1,430,255.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,132,800.00	1,144,204.68
210204	Ажилгүйдлийн даатгал	283,200.00	281,863.82
210205	Эрүүл мэндийн даатгал	2,831,900.00	2,818,639.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,475,044.00	17,624,797.00
210301	Гэрэл, цахилгаан	777,044.00	1,193,497.00
210302	Түлш, халаалт	15,210,480.00	15,210,480.00
210303	Цэвэр, бохир ус	487,520.00	1,220,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,674,587.00	8,900,970.00
210401	Бичиг хэрэг	1,238,380.00	630,650.00
210402	Тээвэр, шатахуун	3,380,000.00	4,317,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,147.00	2,537,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	266,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	808,060.00	1,148,100.00
2105	Нормативт зардал	839,980.00	3,106,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	839,980.00	781,200.00
210502	Хоол, хүнс	0.00	2,325,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,929,520.00	3,383,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,699,220.00	640,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	330,300.00	1,339,200.00
210604	Урсгал засвар	900,000.00	1,403,700.00
2107	Томилолт, зочны зардал	6,752,500.00	6,595,200.00
210702	Дотоод албан томиллолт	6,752,500.00	6,595,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,027,392.00	1,191,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,000.00	114,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120,000.00	110,000.00
210807	Газрын төлбөр	15,392.00	15,390.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	17,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	778,000.00	863,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,199,350.00	5,584,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000,000.00	3,093,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,199,350.00	2,491,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,934,296.00	41,814,770.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,880,000.00	19,309,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	16,749,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,880,000.00	2,560,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	22,505,770.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	22,505,770.74

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,054,296.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,054,296.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>48,410,480.00</u>	<u>4,359,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>52,410,480.00</u>	<u>4,359,700.00</u>
222001	Тоног төхөөрөмж	52,410,480.00	4,359,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(52,410,480.00)</u>	<u>(4,359,700.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,000,000.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(31,364,786.23)	333,148,153.11
C02	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(31,364,786.23)	333,148,153.11
C03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(31,364,786.23)	333,148,153.11
D05	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	18,034,272.12	18,034,272.12
D06	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(13,330,514.11)	351,182,425.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	227,946,200.00	250,085,201.00	109.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	227,946,200.00	245,725,501.00	107.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	208,630,800.00	203,910,730.26	97.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,912,200.00	143,889,694.00	99.98
210101	Үндсэн цалин	105,616,500.00	107,848,149.00	102.11
210102	Нэмэгдэл	33,675,700.00	32,206,545.00	95.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,620,000.00	3,835,000.00	83.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,988,900.00	17,832,539.26	99.13
210201	Тэтгэврийн даатгал	12,232,500.00	12,157,575.94	99.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,439,100.00	1,430,255.74	99.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,151,300.00	1,144,204.68	99.38

210204	Ажилгүйдлийн даатгал	287,800.00	281,863.82	97.94
210205	Эрүүл мэндийн даатгал	2,878,200.00	2,818,639.08	97.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,628,100.00	17,624,797.00	99.98
210301	Гэрэл, цахилгаан	1,218,000.00	1,193,497.00	97.99
210302	Түлш, халаалт	15,252,600.00	15,210,480.00	99.72
210303	Цэвэр, бохир ус	1,157,500.00	1,220,820.00	105.47
2104	Хангамж, бараа материалын зардал	8,003,100.00	8,003,090.00	100.00
210401	Бичиг хэрэг	627,600.00	630,650.00	100.49
210402	Тээвэр, шатахуун	3,420,400.00	3,420,000.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,569,300.00	2,537,640.00	98.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	267,400.00	266,700.00	99.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,118,400.00	1,148,100.00	102.66
2105	Нормативт зардал	781,200.00	781,200.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	781,200.00	781,200.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,742,900.00	3,383,200.00	43.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	640,300.00	12.81
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,339,200.00	1,339,200.00	100.00
210604	Урсгал засвар	1,403,700.00	1,403,700.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,595,200.00	6,595,200.00	100.00
210702	Дотоод албан томилолт	6,595,200.00	6,595,200.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,369,900.00	1,191,990.00	87.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	114,000.00	95.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	111,600.00	110,000.00	98.57
210807	Газрын төлбөр	20,000.00	15,390.00	76.95
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38,100.00	17,400.00	45.67
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	863,200.00	863,200.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,609,300.00	4,609,020.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,093,300.00	3,093,020.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,516,000.00	1,516,000.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,315,400.00	41,814,770.74	216.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	22,505,770.74	0.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	22,505,770.74	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,749,000.00	16,749,000.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,566,400.00	2,560,000.00	99.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	4,359,700.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	4,359,700.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,630,800.00	250,085,201.00	119.87
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,110,800.00	191,426,200.00	111.22
131001	Улсын төсвөөс санхүүжих	172,110,800.00	191,426,200.00	111.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	36,520,000.00	58,659,001.00	160.62
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,520,000.00	58,659,001.00	160.62

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
------------	----------	-----------

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,197,880.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,197,880.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,197,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	897,880.00
210402	Тээвэр, шатахуун	897,880.00
2105	Нормативт зардал	2,325,000.00
210502	Хоол, хүнс	2,325,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	975,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	975,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,197,880.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,197,880.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	897,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,300,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь СХЗГ-ын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/118 тоот тушаалын хавсралтаар батласан захиргааны болон төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлийг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулдаг.

2022 онд үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч” шагнал олгох журмын төслийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2022 оны А/262 тоот захирамжаар батлуулсан.

Мөн СХЗГ-ын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газартай хамтран MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо - шаардлагатай стандарт"-ын чиглэлээр сургалтыг зохион байгуулсан.

"Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг хангахад стандартчилал, хэмжил зүйн бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд тайлант онд 13 зорилт дэвшүүлж хэрэгжүүлж ажилласан.

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 705 дугаар тогтоолын дагуу нийт 9,385,4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан. Ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэ шинэчлэн тогтоох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, 2022 оны “Үндсэн хөрөнгө дахин үнэлж, ашиглалтын хугацаа болон шинэчилсэн үнэ тогтоох зөвшөөрөл олгох тухай” 657 дугаар тогтоолын дагуу 52,626.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данс бүртгэлээс хааж, шинээр 27,948.0 мянган төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.

2022 онд Стандарт хэмжил зүйн газрын болон аймгийн Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 98 хувийн биелэлтэйгээр тайлагнасан байна. 2022 онд үйл ажиллагааны

орлогын төлөвлөгөөг 36,520.0 мянган төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 58,659.0 мянган төгрөг буюу 160.6 хувиар биелүүлсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг СХЗГ-ын даргын 2022 оны А/101 тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс

програм хангамж нь 2018 оноос хойш шинэчлэгдэн онлайн-ар холбогдож тайлан мэдээгээ гаргадаг давуу талтай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,284.2 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	13,425.5	16,070.5	2,645.0
Үндсэн хөрөнгө	319,722.7	337,361.9	17,639.2
Нийт хөрөнгө	333,148.2	353,432.4	20,284.2
Өр төлбөр		2,250.0	2,250.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	333,148.2	351,182.4	18,034.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	333,148.2	353,432.4	20,284.2

2022 онд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь худалдан авсан бараа материал 2,645.0 мянган төгрөг, үнэгүй авсан үндсэн хөрөнгө 17,639.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Шатахууны өглөг 300.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,950.0 мянган төгрөг бүгд 2,250.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. СХЗГ-аас санхүүжилт дутуу олгосон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 250,4 сая, үйл ажиллагааны орлогоос 35.0 сая, нийт зарлагыг 285.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 203.7 сая, зардлыг 81.7 сая төгрөгөөр бууруулж, 203.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан өмнөх оны санхүүжилттэй харьцуулж, шийдвэрлэсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 21.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 172.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 36.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна.

Зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 99.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2022 онд баайгууллагын үйлчилгээний орлогоос нэмэлт санхүүжилтээр 4,197.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган нар хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогын 206,195.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,092,9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эд хогшил, урсгал засварын зардлыг 56.3 хувь буюу 4,359.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйчилгээний зардлыг 13.0 хувь буюу 178.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус хэлтэс 2022 онд шилэн дансны сайтад 147 мэдээлэл байршуулахаас 144-ийг цаг тухай бүрд нь мэдээлсэн ба 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12-наас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээллийг авч танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2022.6.08-ны 64 тоотойр төлбөрийн акт, 65 тоотойр албан шаадлагын хариу, 66 тоотойр зөвлөмжийн биелэлт тус тус Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	220.0	1	220.0	100.0
Албан шаардлага	2	1,800.0	2	1,800.0	100.0
Зөвлөмж	3	3,022.7	3	3,022.7	100.0
Нийт дүн	6	5,042.7	6	5,042.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт болон завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 12,945.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн² нэг алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Аж ахуйн материалын данснаас бусад хангамжийн материалд 12,945.9 мянган төгрөгийн дансны бичилтийг буруу хийсэн.

2. Хэлтсийн үнэт цаасанд тооцон хагалагдаж буй гэрчилгээнүүдэд тооллого хийхэд ажлын онцлогтой холбоотой гэсэн үндэслэлээр лабораторийн болон байцаагчийн тэмдэг дарагдсан гэрчигээнүүд хадгалагдаж байв.

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн материалын данснаас бусад хангамжийн материалд 12,945.9 мянган төгрөгийн дансны бичилтийг буруу хийсэн. Энэ нь санхүүгийн тайлангийн эдийн засгийн ангилал буруу илэрхийлэгдэх, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга УСНББОУС бусад, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-д: Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна., 15.2-т: Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна. гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг эдийн засгийн зөв ангиллын дагуу бүртгэж, илэрхийлж байх

2. Үнэт цаасны хадгалалт, зарцуулалт, хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хэлтсийн үнэт цаасанд тооцон хагалагдаж буй гэрчилгээнүүдэд тооллого хийхэд няравт 5, 2 мэргэжилтэнд 5 гэрчилгээний маягт ажлын онцлогтой холбоотой гэсэн үндэслэлээр лабораторийн болон байцаагчийн тэмдэг дарагдснаар хадгалагдаж байв. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д: Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна. гэсэн эрх зүйн актын заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	1	12,945.9					1	12,945.9			1	12,945.9
Дүн	1	12,945.9					1	12,945.9			1	12,945.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрх зүйн актыг мөрдөөгүй	1	0.0					1	0.0				
Дүн	1	0.0					1	0.0				